



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/89

Улаанбаатар хот

Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний
хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар 8.3.1, 8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.2022 онд батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулан ажиллахыг Үнэлгээний хороо (М.Долгион)-д үүрэг болгосугай.

2.Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл"-ийг гаргуулан байгууллагын ЭБАТ-д бүртгүүлж, худалдан авах ажиллагаатай холбогдох баримт бичгээр архивын нэгж үүсгэж, холбогдох албан тушаалтад хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Халиунаа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Д.НАРАНТУЯА

1422 010309

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 20.2.2 оны 04 дугаар сарын 26 -ны
өдрийн 07/ дугаар тушаалын хавсралт



**ЭМ БЭЛДМЭЛ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ
НИЙЛҮҮЛЭГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

М.Долгион (ЭЭХХЗГ, ЭАБТСГ-ын мэргэжилтэн)

Гишүүд:

М.Энхжаргал (ЭЭХХЗГ, ЗУГ-ын мэргэжилтэн)

Б.Батжаргал (Эрүүл мэндийн технологи
инновацийн хамтын ажиллагааны хүрээлэн
НҮТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн)

Т.Отгонтөгс (Сэтгэлд мөнхрөх үйлс ТББ-ын
зохицуулагч)

Нарийн бичгийн дарга:

Ж.Халиунаа (ЭЭХХЗГ, ЭТТГ-ын мэргэжилтэн)